

Суралцагчийн нийгэм, сэтгэл зүйн асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Пүрэв-Очир Жаргалтуяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Суралцагчийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшихүй, сэтгэл зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр баримтлах бодлого, эрх зүйн баримт бичиг, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах							
1	Суралцагчийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшихүй, сэтгэл зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр баримтлах бодлого, эрх зүйн баримт бичиг, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах	Хэрэгжүүлэх арга хэмжээ /тоо/	1	2	1."Боловсролын салбарын бодлогын хэрэгжилтэд удирдах ажилтны манлайлал" сургалт зохион байгуулж, Төв аймгийн 35 захирал, 39 эрхлэгч, дарга, 3 мэргэжилтэн, нийт 79 хүн хамрагдсан. 2."Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх" сургалт зохион байгуулж, сургуулийн 33 нийгмийн ажилтан, 6 сэтгэл зүйч, 13 эмч, цэцэрлэгийн 22 арга зүйч, 13 эмч, 16 багш, нийт 99 хүн хамруулсан.	2-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	90%

					3.Төв, Завхан, Дорнод аймгийн боловсролын газрын мэргэжилтнүүд, тус аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр чадваржуулах 3 удаагийн сургалтыг 2025 оны 2-3 дугаар саруудад зохион байгуулсан. Сургалтад нийт 75 нийгмийн ажилтан, 15 сэтгэл зүйч танхимаар хамрагдсан. Хавсралт: 1 файл		
2	Суралцагчийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшихүй, сэтгэл зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр дүрэм, журамд нийцсэн арга зүй удирдлагаар хангахад чиглэсэн видео, шкорк бэлтгэх	Хэрэгжүүлэх арга хэмжээ /тоо/	1	1	1. БШУЯ-тай хамтран Сэтгэл зүйч Б.Золзаяатай "Өсвөр насны хүүхдийн шалгалтын айдас, хэрхэн даван туулах түүнд эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө" сэдвээр 3 цуврал ярилцлага видеог хийж олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн. 2. БЕГ-ын пейж хуудсаар өсвөр насны сурагчад зориулан "Шалгалтын өмнөх үеийн сэтгэл зүй" сэдвээр постер хийж түгээсэн. 3. Таны "хүсэж буй хүүхдийн төр төрх" чиглэлээр эцэг эх, асран хамгаалалчдад 2 цуврал постер мэдээлэл БЕГ-ын пейж хуудсаар дамжуулан түгээсэн. 4. Цахим орчинд эерэг харилцааг бий болгох аргууд сэдвээр 3 цуврал постер бэлтгэж БЕГ-ын пейж хуудсаар дамжуулан түгээсэн. 5. 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын биелэлтийн үр дүнгийн мэдээллийн постер хэлбэрээр бэлтгэж БЕГ-ын пейж хуудсаар түгээн дэлгэрүүлсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Хавсралт: 1 файл		
3	Ерөнхий боловсролын сургуульд ажиллах сэтгэл зүйчийг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт /тоо/	-	1	1. “Боловсролын сэтгэл зүйчийн мэргэшүүлэх 9 дэх” удаагийн сургалтад хамруулах 2 үе шат бүхий сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, баримт бичгийн шалгаруулалтад 102 материал ирснээс 74 материал шалгарч түүнээс ярилцлагын сонгон шалгаруулалтад 54 сэтгэл зүйч тэнцсэн. Ингэснээр мэргэжүүлэх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 02 дугаар сарын 24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод танхимаар зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн 28, орон нутгийн 23 сэтгэл зүйч суралцаж төгсөж цаашид ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтан, сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэн амжилттай ажиллаж байна. 2. 2024-2025 оны хичээлийн жилд ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 420 гаруй сэтгэл зүйчийг чадваржуулах богино хугацааны сургалтад хамрууллаа. Сургалт 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд үргэлжилсэн. Сургалтаар сэтгэл зүйчийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх ур чадвар, бага насны хүүхэдтэй тоглоомын аргаар дамжуулан сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, бусадтай харилцах чадварыг нэмэгдүүлэх арга зүйг эзэмшүүлсэн.	1-р сар, 5-р сар, 10-р сар	100%

					Хавсралт: 2 файл		
4	Сэтгэл зүйчийг "Жендер"-ийн чиглэлээр мэргэшүүлэх сургалт, бусад үйл ажиллагаа зохион байгуулах	Хэрэгжүүлэх арга хэмжээ /тоо/	-	1	Ерөнхий боловсролын сургуульд анхны жилдээ ажиллаж буй 86 сэтгэл зүйчид зориулан "Жендерийн тухай үндсэн ойлголт", "жендерийн мэдрэмжтэй ажиллах нь" чиглэлээр Жендерийн үндэсний хороотой хамтран 10 цагийн сургалтыг цахимаар зохион байгуулсан байна. Ингэснээр өөрийн ажиллаж буй сургуулийн багш, ажилтанд энэ чиглэлээрх зөвлөгөө мэдээллийг нөлөөллийн ажлаар дамжуулан 2 дах шатны сургалтыг зохион байгуулж энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн.	2-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 11-р сар	100%

1.2. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцаа, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх

5	Суралцагчийн нийгэмшихүй, сэтгэл зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг эх, олон нийттэй хамтран ажиллаж буй сургууль, сэтгэл зүйчийн сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	1	1	1. Сурагчдын амралтад зориулан "цагийг хэрхэн үр дүнтэй өнгөрүүлэх вэ?", "амьралын зөв дадал хэвшилтэй болох нь" зэрэг чиглэлээр цуврал мэдээллийг дунд ахлах ангийн сурагчдад зориулан нийтэлсэн. Эцэг эх, асран хамгаалагчдад зориулан хүүхдийнхээ сэтгэл зүйг таньж харилцах, тайвшруулах чиглэлээр цуврал мэдээллийг хүргэсэн. Цаашид ерөнхий боловсролын сургуульд ажилладаг сэтгэл зүйчдэдээ зориулан мэргэжлийн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдтэй хамтран ярилцлага видео БЕГ-ын пейж хуудсаар нийтлэхээр бэлтгэсэн.	1-р сар, 3-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	90%
---	---	--------------------------------	---	---	---	---	-----

					2.Боловсролын сэтгэл зүйчийн эрх зүйн орчин, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг, тушаал шийдвэр, ажлын үр дүнг үзүүлсэн 4 цуврал постер мэдээллийг БЕГ-ын пейж хуудсаар түгээн дүлгэрүүлсэн. 3. Орхон аймгийн 14 дүгээр сургуулийн сэтгэл зүйчийн сайн туршлагыг БЕГ-ын пейж хуудсаар түгээн дэлгэрүүлж олон нийтэд мэдээлсэн. Хавсралт: 1 файл		
6	Сэтгэл судлал мэргэжлээр их, дээд сургууль төгсөгч оюутнуудын мэдээллийн сан бүрдүүлэх, ерөнхий боловсролын сургуульд ажиллах сэтгэл зүйчийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	1	1	1. 2024-2025 оны хичээлийн жилд "Сэтгэл судлал" мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж байгаа 2250 оюутны тоон мэдээллийн санг бүрдүүлсэн. Их, дээд сургуульд "Сэтгэл судлал" мэргэжлээр 4 дүгээр түвшинд суралцаж байгаа 600 оюутны мэдээллийг боловсруулсан. МУБИС, МУИС, Хүмүүнлэг, Отгонтэнгэр сургуулиудын мэргэжлийн тэнхимүүдтэй хэрхэн хамтран ажиллаж төгсөгчийг ажлын байранд зуучлах талаарх хэлэлцүүлгийг онлайн хэлбэрээр зохион байгуулсан. 2. МУБИС-ын БоСС-ын сэтгэл судлал арга зүйн тэнхимтэй хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Үүнд анхны "Сургуулийн сэтгэл зүйч"-ийн ангийг төгсөх 26 оюутны хаана ажиллах судалгааг авч, үр дүнд үндэслэн орон нутаг болон дүүргийн	2-р сар, 4-р сар, 6-р сар, 10-р сар, 12-р сар	100%

					ерөнхий боловсролын сургуультай холбож, төгсөгчдидтэй гэрээ байгуулан шууд ажлын байраар хангах ажлыг төлөвлөгөөний дагуу бэлтгэж байна. Тус арга хэмжээ 2025 оны 06 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдана.		
7	Суралцагчийн нийгэм, сэтгэл зүйн асуудлаар олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	Зохион байгуулсан барга хэмжээний тоо	1	1	1. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд "Өсвөр, залуу үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг аппликешнээр дамжуулан үзүүлэх" төсөл хэрэгжүүлэхээр санаачлан төлөвлөсөн. Тус төсөл нь алслагдсан бүс нутгийн сэтгэл зүйч ажилдаггүй 100 сургуульд хэрэгжих бөгөөд 70 сая төгрөгийн санхүүжилттэй тул нээлттэй тендер зарлахаар шийдвэрлэсэн. Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн өсвөр залуу үеийнхэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр tender.gov.mn сайтад тендэрийн баримт бичгийг байршуулсан. 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр тендер нээгдэж Про крафт компани материалаа ирүүлснийг үнэлгээ хороо шалгаж үзсэн. Ингэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	1-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					тухай хуулийн 28.1.23 дахь заалтад заасны дагуу татагалзсан дүгнэлтийг гаргаж ажилласан. 2. JCI central салбар байгууллагатай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд сэтгэл зүйчийг чадваржуулах сургалт зохион байгууллаа. Сургалтад төрийн болон хувийн хэвшлийн ЕБС-д ажиллаж байгаа 420 гаруй сэтгэл зүйч хамрагдлаа. Хавсралт: 2 файл		
3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх							
8	Боловсролын ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурал, Суралцагчийн хөгжлийн газрын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	80	100	1. Нийслэлийн, аймгийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт СХГ-аас 2025.04.08-ны өдөр зохион байгуулах шуурхай хуралдааны хөтөлбөрийг боловсруулж, хянуулах, цахим хурлын линк үүсгэж, хурлын зарыг хүргэх /2025.04.07-ны өдөр/, цахим хурлыг удирдан зохион байгуулах /2025.04.08-ны өдөр/ 2. “ХҮҮХЭД ТӨВТЭЙ” PBL, TIME MANAGEMENT, 3P төслийн "project based learning & time management" төслийн хэрэгжилт, үр дүнг танилцуулах, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг хамруулан хамтран ажилласан. Үйл ажиллагаа 2025 оны 05 дугаар сарын 01-гы	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					өдрөөс 02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. 3. Боловсролын сайдын 2024 оны А/229 дүгээр тушаалаар байгуулагдсан "Сургуулийн соёл-Суралцагчийн төлөвшил" ажлын хэсэгт ажиллаж удирдамж боловсруулсан. 4. Хүүхдийн байгууллага үүсэж, хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан "Хүүхдийн хөгжил,төлөвшлийн цаг" арга хэмжээг зохион байгуулах чиглэл, албан тоот бичгийг боловсруулан Аймаг, нийслэлийн боловсролын байгууллагад хүргүүлсэн. Хавсралт: 3 файл		
3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
9	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	1	100	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1.ТАХ-ийн 2024 оны архивын нэгжийг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн. 2. Үе тэнгийн дээрэлхэлтийн тухай	1-р сар, 3-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					157 дугаар сургуулийн Н охины ээжийн өргөдлийн дагуу тус сургуульд ажиллаж БЕГ-ын даргад тайлагнасан. 3. Монгол Орос-3 дугаар сургуульд суралцах эрх нь зөрчигдсөн сурагч А охины ээжийн гомдлын дагуу Боловсролын ерөнхий газрын даргын 12 сарын 27-ны А/417 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Ажил мэргэжлийн чиглэлийн дагуу дагуу уулзалт, зөвлөгөөн, форум, сургалт, чуулганд хамрагдах;	Сургалтад хөтөлбөрийн дагуу хамрагдаж цаг үеийн мэдээ мэдээлэл авна.	1	2	1. НДЕГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагчдад таниулах, мэдээллээр хангах сургалт 2. ЗУГ-аас зохион байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэлт мэдээллийн сургалтад хамрагдсан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					3. Өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Сургагч багшийн сургалтад хамрагдав. 4. НҮБ-ын ХАС-ийн "Ээлтэй сургууль" төслийн сургалтад хамрагдан үндэсний сургагч багш 5. “ХҮҮХЭД ТӨВТЭЙ” PBL, TIME MANAGEMENT, 3P төслийн сургагч багшийн сургалтад хамрагдсан. 6. Бусад цаг үеийн уулзалт зөвлөгөөнд бүрэн хамрагдсан		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн нийгэм, сэтгэл зүйн асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Пүрэв-Очир Жаргалтуяа /...../

Огноо: